



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Аудитыг дуусвар болгосон

тухай тайлан

АГУУЛГА

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

САГ-ындарга: С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг:
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер:
Л.Одгэрэл
Утас: 261628
Цахим хаяг:
odgerell@audit.gov.mn

Аудитор: Р.Цолмон
Утас: 261628
Цахим хаяг:
tsolmonr@audit.gov.mn

Монгол Улсын
Үндэсний Аудитын Газар
Улаанбаатар,
Бага тойруу,
Засгийн газрын IY байр
Цахим хуудас: www.audit.mn

2014 оны 4 дүгээр сар

Оршил
Санхүүгийн дотоод хяналт
Илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
Аудитын санал дүгнэлт

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

Хавсралт 4: Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн
тайлан

Оршил

Боловсрол, шинжлэх ухааны сайдын төсвийн багцын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитыг дуусгавар болгосон тухай энэхүү тайланг тус газрын удирдлагад танилцуулж байна.

Менежментийн захидалд санхүүгийн хяналтын журмыг сайжруулах талаарх бидний зөвлөмжүүд болон манай зөвлөмжийн талаар тус төслийн ирүүлсэн хариуг тусгасан болно.

Аудитын явцадмөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлого, дансны нэгдсэн жагсаалт, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, дансны болон ерөнхий журнал, ерөнхий дэвтэр зэрэг хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзлээ.

Боловсрол шинжлэх ухааны сайдын төсвийн багцын 2012 оны санхүүгийн тайланд 1829 байгууллага нэгтгэгдэж байснаас 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд БШУЯ-ны аппарат, Боловсролын төвлөрсөн арга хэмжээ, тус салбарын хөрөнгө оруулалт, их засвар, “Ээлт-Өргөө” УҮГ, ШУТС, СТС гэх зэрэг харъяа 28 байгууллага, төрийн өмчийн 8 их, дээд сургууль, аймаг, нийслэлийн 23 боловсролын газар, хэлтэс, орон нутаг дах газар хөдлөлийн 9 станц, Азийн хөгжлийн болон Дэлхийн банкны 6 төсөл, нийт 74 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Тайлант онд БШУС-ын төсвийн багц нийт 1,037.5 тэрбум төгрөгөөр батлагдсан ба үүний 32.8 хувьд ҮАГ, 1.1 хувьд аймаг, нийслэлийн Аудитын газар, 3.3 хувьд хувийн аудитын компани гэрээгээр аудит хийсэн болно. АХБ-ны Дээд боловсролын шинэчлэл төслийн аудит хийх хугацаа болоогүйгээс аудит хийгдсэн санхүүгийн тайлан нэгтгэгдээгүй байна.

Санхүүгийн дотоод хяналт

Боловсрол, шинжлэх ухааны сайдын төсвийн багцынХяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь 2013 оны санхүүгийн тайланд хяналт тавьж, үнэлгээ хийгдээгүй нь орон тооны асуудал шийдээгүйгээс шалтгаалсан байна.

Аудитаар дээд түвшний хяналтын 3 асуудал хөндөгдсөн бөгөөд Боловсрол, шинжлэх ухааны сайдын анхааралд хандуулж байна. Үүнд:

Тусгай зориулалтын шилжүүлэгтэй холбоотой асуудлууд:

- Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.4¹, 61.5²-д заасны дагуу тусгай зориулалтын шилжүүлгээр аймаг, нийслэлийн сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын урсгал зардалд нийт 646.7 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан нь

¹Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.4-т “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасан гэрээ, Засаг даргын өргөн мэдүүлсэн саналд үндэслэн төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүрэг бүрээр хуваарилсан санхүүжилтийг энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасан гэрээгээр шилжүүлсэн нийт хэмжээнээс бууруулахгүйгээр орон нутгийн төсвийн нэг хэсэг болгож батална”

²Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.5-д “Тусгай зориулалтын шилжүүлгийг энэ хуульд заасан сар, улиралын хуваарийн дагуу аймаг, нийслэлийн төрийн санд шилжүүлнэ” гэж заасан.

салбарын нийт багцын батлагдсан төсвийн 62.3 хувь, урсгал төсвийн 72.7 хувийг эзэлж байна. Үүнээс 30.0 хувь буюу 194.3 тэрбум төгрөгийг сургуулийн өмнөх боловсролд, 70.0 хувь буюу 452.3 тэрбум төгрөгийг ерөнхий боловсролд олгосон байна. Тайлант оны гүйцэтгэлээр 642.0 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан байна.

- БШУС-ын төсвийн багцын нийт хөрөнгийн 2013 оны эхний үлдэгдэл 1,298,886.5 сая төгрөг байснаас оны эцэст 408,964.9 сая төгрөг болж, 885,478.8 сая төгрөгөөр буурсан нь УИХ-ын 1999 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчлөлд шилжүүлэх эд хөрөнгийн жагсаалт” болон Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1³, 61.1.2⁴ Сангийн сайдын 2013 оны 7 дугаар сарын 9-1/3994 дугаар албан бичгийг үндэслэн орон нутгийн салбар байгууллагуудын хөрөнгийг /724 хүүхдийн цэцэрлэг, 618 ерөнхий боловсролын сургууль/ орон нутагт шилжүүлсэнтэй холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэлийн талаар:

- БШУС-ын төсвийн багцын төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төсвийг нийт дүнгээр 90,760.0 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсан боловч зарим зардлыг хэтрүүлэн зарцуулсан байна. Тухайлбал: Нийгмийн шинжлэх ухааны байгууллагуудын зардлыг 153.3 сая төгрөгөөр, Анагаах ухааны шинжлэх ухааны байгууллагуудын зардлыг 59.6 сая төгрөгөөр, Хөдөө аж ахуйн эрдэм шинжилгээний байгууллагуудын зардлыг 274.8 сая төгрөгөөр, Байгалийн шинжлэх ухааны эрдэм шинжилгээний байгууллагуудын зардлыг 1,216.0 сая төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан байна.

Аудитаар илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд

Тус ерөнхийлөн захирагчид хамаардаг байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг нэгтгэн хураангуйлан тэмдэглэв.

Нэг.Төсвийн шууд захирагч нарын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зарим зөрчлүүд:

1.1 Тооллогоор үндсэн хөрөнгө дутагдаж, зарим үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн байна.

Хөгжим бүжгийн коллежийн 2013 оны жилийн эцсийн үндсэн хөрөнгийн тооллогоор урлах эрдмийн хашаа 0.2сая төгрөг, агуулах склад 2.5сая төгрөг нийт 2.7 саятөгрөгийн, “Шинэ-Эхлэл” ОУ-ын Лаборатори сургуулийн 22,3 сая төгрөгийн үнэтэй 5 төрлийн 240 ширхэг хөрөнгө тус тус дутагдсан байна.Энэ нь бүртгэлээр тавих хяналт сул байгааг харуулж байна.

³Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1-д “ Аймаг, нийслэлийн Засаг дарга Засгийн газрын дараах чиг үүргийг орон нутгийн сургуулийн өмнөх боловсролд төлөөлөн хэрэгжүүлнэ” гэж заасан.

⁴Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.2-д “Аймаг, нийслэлийн Засаг дарга Засгийн газрын дараах чиг үүргийг орон нутгийн ерөнхий боловсролд төлөөлөн хэрэгжүүлнэ” гэж заасан.

Мөн Соёл Урлагын Их сургуулийнтөв болон салбар 7 сургуулийн үндсэн хөрөнгө, бараа материалын дансны бүртгэлээс үзэхэд үндсэн хөрөнгийн шинж чанар агуулсан 169 нэр төрлийн 114.2 сая төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгүүд бараа материал /хангамжийн материал/-ын дансанд бүртгэлтэй байгаа тул бараа материалын данснаас хасч үндсэн хөрөнгийн дансанд ангиллын дагуу шилжүүлэн бүртгэх талаар зөвлөмж өглөө.

1.2 12,800.0 сая төгрөгийн хүүгийн авлага хуримтлагдаж, 150.0 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Гэгээрлийн сайд, Сангийн яамны санхүү эдийн засгийн сайд /хуучнаар/-ын хамтарсан тушаалаар баталсан Өндөр хөгжилтэй орны магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журмын 2.7-д⁵ заасны дагуу 2004 оноос хойш өндөр хөгжилтэй оронд суралцагчдаас авах хүүгийн 12.8 тэрбум төгрөгийн авлагыг тооцсон байна. Иймд тус хүүгийн авлагыг барагдуулах талаар холбогдох арга хэмжээ авах талаар зөвлөмж өглөө.

“Ээлт-Өргөө” УҮГ-ын тайлант оны санхүүгийн тайлангийн авлагын дансанд бүртгэлтэй “Ховдтул”ХХК-нд олгосон 150.0 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

1.3 Анхан шатны баримт материалын бүрдүүлэлт дутуу байна.

Анагаах Ухааны хүрээлэн анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлэлгүйгээр нийт 29.3 сая төгрөгийн бэлэн мөнгөний зарлагын гүйлгээ хийсэн, Шинжлэх ухаан технологийн их сургууль эрх бүхий албан тушаалтны тушаал, шийдвэр болон бусад анхан шатны баримтын бүрдүүлэлтгүйгээр 81.9 сая төгрөгийг зарцуулсан зөрчил илэрсэн байна.

1.4 Зарим зардлыг хэтрүүлэн зарцуулж, зориулалт бус зардал гаргасан байна.

Соёл Урлагын Их сургуулийн 2013 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаас үзэхэд төсвийн зарлагыг нийт 1,084.6 сая төгрөгөөр буюу 30.5 хувиар хэтрүүлэн зарцуулсан нь үндсэн үйл ажиллагаа /сурлагын төлбөр/-ны давсан орлогыг зарцуулснаас шалгаалжээ.

ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар нь дотоод албан томилолтын зардал 1.7 сая төгрөг, сургалт семинарын зардал 2.1 сая төгрөг, төлбөр хураамж жижиг татварууд 0.8 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалын зардал 2.1 сая төгрөг, төвлөрүүлэх шилжүүлэг 0.3 сая төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан байна.

⁵Гэгээрлийн сайд, Сангийн сайдын санхүү эдийн засгийн сайд /хуучнаар/-ын хамтарсан тушаалаар баталсан Өндөр хөгжилтэй орны магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журмын 2.7-д “Суралцагч сургалтын үндсэн хугацаандаа сургуулиа төгсөж чадаагүй, төгсөөд эх орондоо ирээгүй, гэрээнд заасан байгууллагад 5-аас доошгүй жил ажиллаагүй нөхцөлд сургалтын болон тэтгэлэгийн зээлийг авсан өдрөөс эхлэн жилийн дундаж инфляцийн түвшингээс 1.0 хувийн илүү хүүтэйгээр суралцагч буюу итгэмжлэгч нь буцаан төлөх ба уг төлбөрийг барагдуулах асуудлыг гэрээний дагуу Сургалтын төрийн сан хариуцан гүйцэтгэнэ.

БШУЯ-ны аппаратын санхүүжилтээс дэлхийн шилдэг их сургуульд суралцахад дэмжих төвд 9.8 сая төгрөгийг шилжүүлсэн нь зориулалт бус зардал байна.

1.5 Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан журмыг зарим байгууллага мөрдөн ажиллаагүй байна.

Нийслэлийн Боловсролын Газар төсвийн гүйцэтгэлийн тайланд 22.8 сая төгрөгийн өөрийн орлогыг дутуу тайлагнаж, 2.0 сая төгрөгийн бараа материалын орлого, зарлагын тайлан гаргаагүй, Боловсролын үнэлгээний төв “Ган-Асу” ХХК-д нэг бүр нь 3.0 мянган төгрөгийн үнэтэй 7.0 мянган ширхэг лацны үнэнд 21.0 сая төгрөг төлсөн боловч бараа материалыг хүлээж аваагүйгээр бараа материалын дансанд хий орлого авсан, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын шалгалтанд бэлтгэх гарын авлага ном хэвлүүлсэн 60.2 сая төгрөгийг маягт хэвлүүлсний зардалд, 2013 оны номын борлуулалтын орлого нийт 73.7 сая төгрөгийг бусад орлогын дансаар бүртгэсэн, угномыг борлуулагч нарт олгохдоо авлагын дансанд авлага үүсгэн бүртгээгүй зөрчлүүд гаргасан байна.

1.6 “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийг мөрдөж ажиллаагүй байна.

Нийслэлийн боловсролын газар хөрөнгө оруулалтынажлын барьцаа 18.4 сая төгрөгийг аваагүй, Анагаах ухааны хүрээлэн МУИС-ийн төвлөрсөн сангийн хөрөнгөөр санхүүжсэн их засварын ажлын гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулалт хийхдээ тендерт оролцогчийн санхүүгийн чадавхийг үнэлээгүй, ажлын гүйцэтгэл, магадлашгүй ажлын актгүйгээр 3.3 сая төгрөгийн илүү санхүүжилт олгосон байна.

Хоёр. Орон нутгийн салбарын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зарим томоохон зөрчлүүд:

2.1 Цалин хөлс, нэмэгдэл урамшуулалыг илүү олгосон байна.

Дархан-Уулаймгийн Боловсролын газар унаа, хоолны хөнгөлөлт болох 0.2 сая төгрөгийг давхардуулж, Дорноговь аймгийн Боловсролын газар нийт 6 хүнд амралт болон ур чадварын нэмэгдлийг 1.5 сая төгрөгөөр илүү, Төв аймгийн Боловсролын газар давхардсан тоогоор нийт 43 хүнд 2.8 сая төгрөгийн илүү цагийн мөнгө тус тус олгосон зөрчил гарсан байна.

2.2 Үндсэн хөрөнгийг бүртгэлд бүрэн тусгаагүй байна.

Сүхбаатар аймгийн Боловсролын газар “Хөдөөгийн эмзэг бүлгийг дэмжих төсөл”-өөр ирсэн 5.1 сая, Боловсрол шинжлэх ухааны яамнаас ирсэн 12.0 сая, Дорноговь аймгийн Боловсролын газар “Хөдөөгийн эмзэг бүлгийг дэмжих төсөл”-өөс ирсэн 5.1 сая, БШУЯ-наас ирсэн 12.0 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгийн бүртгэлд тус тус тусгаагүй байна.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийг нэгтгэж дурдвал:

БШУС-ын багцын санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан 74 байгууллагын 42 байгууллагад зөрчилгүй дүгнэлт, 8 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт өгчээ. Үүнээс хязгаарлалттай дүгнэлт авсан байгууллагууд:

-Шинэ эхлэл-Олон Улсын Хөтөлбөрийн сургалттай төрийн өмчит ерөнхий боловсролын сургууль

-Хөдөө аж ахуйн их сургууль

-Соёл урлагын их сургууль

-Ховд их сургууль

-ХААИС-ын Дарханы Ургамал газар тариалангийн хүрээлэн

-Завхан аймгийн Боловсролын газар

-Төв аймгийн Боловсролын газар

-Увс аймгийн Боловсролын газар

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 15,504.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсний 40.9 сая төгрөгийн зөрчилд 16 акт, 54.8 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага тус тус бичигдсэн бөгөөд аудитын явцад 939.6 сая төгрөгийн алдааг залруулж, 14,564.9 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах талаар 106 зөвлөмж өгсөн байна.

Бидний олж илрүүлсэн асуудлын чиглэлд дотоод хяналтыг илүү сайжруулах, харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд дахь Сангийн сайдын баталсан заавар, журмын хэрэгжилтэд хяналт тавих шаардлагатай байна.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Боловсрол, шинжлэх ухааны сайдын төсвийн багцын 2012 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд ҮАГ-аас 5 зөвлөмж өгсөний 4 зөвлөмж биелэгдэж, 1 зөвлөмж биелэгдэх шатандаа байна. Мөн аймаг, нийслэлийн Боловсролын газар болон Газар, хөдлөлийн станцад өгсөн нийт 134 зөвлөмжөөс 108 зөвлөмж нь биелэгдэж, зөвлөмжийн биелэлт 80.6 хувьтай байна.

Аудитын санал дүгнэлт

Боловсрол, шинжлэх ухааны сайдын төсвийн багцын 2013 оны санхүүгийн нэгтгэсэнтайланд “**зөрчилгүй**” санал дүгнэлт өгөхийг Монгол Улсын Ерөнхий аудиторт санал болгож байна.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.04.25 № 677

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1 Төсвийн тухай хуулийн 8.9.5-д заасны дагуу Боловсрол, шинжлэх ухааны сайдын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

Боловсрол, шинжлэх ухааны яамны удирдлага нь Төсвийн тухай хуульд заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангуудыг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бодитой илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Боловсрол, шинжлэх ухааны сайдын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР


А.ЗАНГАД



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Санхүүгийн нэгдсэн тайлан

Асуудал 2

Санхүүгийн нэгдсэн тайлан

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг хэрхэн сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандартын дагуу хийгддэг Үндэсний аудитын газрын аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан юм.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянах бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Үндэсний аудитын газар энэхүү зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

ҮАГ-ын ажиглалт

БШУС-ын төсвийн багцын нэгтгэсэн тайлангийн аудитаар 14,564.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн нь төрийн байгууллагын бүртгэлээр тавих хяналт сул байна.

ҮАГ-ын зөвлөмжүүд

Харьяа газрын санхүүгийн тайланд тавих хяналтыг сайжруулж, аймаг, нийслэлийн Аудитын газрын зөвлөмжийг барагдуулах талаар арга хэмжээ авах;

Зөвлөмжийн биелэлтийг нэгдсэн байдлаар нэгтгэн 2014 оны 7 дугаар сарын 30-ны дотор танилцуулах;

Эрсдэлүүд

Төсвийн тухай хуулийг баримтлан ажиллаагүйгээс төсвийг хэтрүүлэн зарцуулах;

Үйлчлүүлэгчийн хариу

2014 оны 7 дугаар сарын 30-ныг хүртэлх хугацаанд зөвлөмжийг биелүүлэх талаар арга хэмжээ авч ажиллана.

ҮАГ-ын ажиглалт

БШУС-ын төсвийн багцын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн 74 байгууллагын 42 байгууллагад зөрчилгүй дүгнэлт, 8 байгууллагад хязгаарлалттай аудитын дүгнэлт авсан байна.

Эрсдэлүүд

Зориулалтын бусаар хөрөнгийг зөвшөөрөлгүй зарцуулснаар үргүй зардал гарах;

ҮАГ-ын зөвлөмжүүд

Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д “.....санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай,дүгнэлт авсан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэсэн заалтыг үндэслэн холбогдох арга хэмжээ авч ҮАГ-т ирүүлэх;

Үйлчлүүлэгчийн хариу

2014 оны 7 дугаар сарын 30-нийг хүртэлх хугацаанд зөвлөмжийг биелүүлэх талаар арга хэмжээ авч ажиллана.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
МӨНГӨН ХӨРӨНГӨ	79,562,097,926.71	81,307,444,559.28
Кассанд байгаа бэлэн мөнгө	75,986,887.99	89,919,400.93
Төгрөг\ ЖМС	75,986,887.99	89,919,400.93
Банкинд байгаа бэлэн мөнгө	75,459,243,282.57	77,551,683,315.09
Төгрөг	75,459,243,282.57	77,551,683,315.09
Төсөвт байгууллагын харилцах	1,661,167,299.99	
Төсөвт байгууллын харилцах (Арилжааны банк)	73,798,075,982.58	74,146,896,814.93
Нэмэлт санхүүжилтийн харилцах		3,404,786,500.16
Замд яваа мөнгөн хөрөнгө	414,900.00	
Хадгаламж	4,026,452,856.15	3,665,841,843.26
АВЛАГА	85,137,665,790.41	99,771,655,409.68
Ажиллагчидтай холбогдсон авлага	197,758,518.44	59,605,170.33
Төлбөртэй үйлчилгээний авлага	5,200,241,570.85	8,156,238,789.05
Татаас, санхүүжилт, (бүтээгдэхүүн нийлүүлэлтийн) авлага	1,142,496,437.85	1,508,511,707.50
Бусад авлага	3,829,602,654.89	6,791,918,948.23
Байгууллагаас авах авлага	1,753,749,072.33	2,601,405,251.19
Гэрэл цахилгааны авлага	11,713,193.00	133,322.00
Түлш халаалтын авлага	99,344,299.76	
Дотоод албан томилолтын авлага	21,100.00	1,920,000.00
Хоолын авлага	47,584,528.81	
Урсгал засварын авлага	18,240,484.00	
Бусад зардлын тооцооны авлага	1,576,845,466.76	2,599,351,929.19
Хувь хүмүүсээс авах авлага	2,075,853,582.56	4,190,513,697.04
Зээлийн авлага	74,767,566,608.38	83,255,380,794.57
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	74,767,566,608.38	83,255,380,794.57
Хувь хүмүүст олгосон зээл	74,767,566,608.38	83,255,380,794.57
Сургалтын төрийн сангийн зээлийн авлага	74,767,566,608.38	83,255,380,794.57
УРЬДЧИЛГАА	3,326,961,231.76	1,355,920,651.66
Бусад урьдчилгаа	3,326,961,231.76	1,355,920,651.66
Урьдчилгаа тооцоо	631,627,360.73	32,345,040.00
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	104,344,503.98	14,206,460.00
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	434,250,544.76	2,125,000.00
Цалингийн урьдчилгаа	75,750,685.99	3,350,000.00
Томилолтын урьдчилгаа	17,281,626.00	12,663,580.00
Урьдчилж гарсан зардал	2,695,333,871.03	1,323,575,611.66
Урьдчилж төлсөн зардал	2,695,333,871.03	1,323,575,611.66
БАРАА МАТЕРИАЛ	55,021,111,809.69	11,053,513,107.55
Түүхий эд материал	5,915,837,051.57	2,150,900,241.17
Тусгай зориулалттай материал	5,527,966,963.86	1,814,955,063.90
Эм боох материал	85,104,070.60	37,098,504.84
Дуусаагүй үйлдвэрлэл	107,381,309.00	138,921,847.64
Бэлэн бүтээгдэхүүн	195,384,708.11	159,924,824.79
Хангамжийн материал	46,571,517,538.60	8,208,454,378.90
Бичиг хэргийн материал	1,757,334,476.76	478,190,104.93
Аж ахуйн материал	19,155,004,506.92	4,765,786,442.20

Сэлбэг хэрэгсэл	452,209,119.14	222,438,598.36
Түлш, шатах тослох материал	2,142,047,993.39	25,503,509.54
Барилгын засварын материал	1,186,596,224.10	322,654,751.45
Хүнсний материал	7,404,263,438.59	248,021,421.80
Малын тэжээл	23,195,951.13	2,611,500.00
Баглаа боодол	314,509,590.87	164,478,060.45
Бусад бараа материал	14,136,356,237.70	1,978,769,990.17
Мал амьтад	997,738,401.05	235,450,736.24
Бусад	1,536,018,818.47	458,707,751.24
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	223,047,836,758.57	193,488,533,728.17
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,075,838,712,189.26	215,476,358,360.17
Биет хөрөнгө	1,074,729,153,956.79	214,529,431,179.77
Барилга, байгууламж, орон сууц	886,182,621,449.31	150,590,760,932.26
Барилга, байгууламж орон сууц - Анхны өртөг	1,653,279,978,906.63	288,707,604,955.38
Барилга, байгууламж орон сууц - Хуримтлагдсан элэгдэл	-767,097,357,457.32	-138,116,844,023.12
Авто-тээврийн хэрэгсэл	5,668,164,176.59	4,259,244,605.65
Авто-тээврийн хэрэгсэл анхны өртөг - Анхны өртөг	9,733,968,301.90	7,393,153,074.50
Авто-тээврийн хэрэгсэл - Хуримтлагдсан элэгдэл	-4,065,804,125.31	-3,133,908,468.85
Машин тоног төхөөрөмж(компьютер)	68,300,202,612.10	32,273,692,249.00
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Анхны өртөг	142,430,516,385.50	74,109,156,053.98
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Хуримтлагдсан элэгдэл	-74,130,313,773.40	-41,835,463,804.98
Тавилга, аж ахуйн эд хогшил	45,614,607,726.57	12,924,570,215.34
Тавилга, аж ахуйн эд хогшил - Анхны өртөг	82,082,420,534.29	25,920,377,353.70
Тавилга, аж ахуйн эд хогшил - Хуримтлагдсан элэгдэл	-36,467,812,807.72	-12,995,807,138.36
Зам, гүүрийн байгууламж	955,178,021.54	620,246,520.37
Зам, гүүрийн байгууламж - Анхны өртөг	3,461,933,405.92	1,014,247,506.52
Зам, гүүрийн байгууламж - Хуримтлагдсан элэгдэл	-2,506,755,384.38	-394,000,986.15
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	184,533,038.02	1,302,304,169.81
Бусад үндсэн хөрөнгө	28,437,368,548.21	7,307,107,935.34
Бусад үндсэн хөрөнгө - Анхны өртөг	38,915,515,917.71	9,550,631,635.98
Бусад үндсэн хөрөнгө - Хуримтлагдсан элэгдэл	-10,478,147,369.50	-2,243,523,700.64
Дуусаагүй барилга, байгууламж	39,386,478,384.45	5,251,504,552.00
Биет бус хөрөнгө	1,109,558,232.47	946,927,180.40
Програм хангамж	842,833,694.65	563,692,227.35
Програм хангамж - Анхны өртөг	1,774,634,586.16	1,129,535,306.00
Програм хангамж - Хуримтлагдсан элэгдэл	-931,800,891.51	-565,843,078.65
Бусад биет бус хөрөнгө	266,724,537.82	383,234,953.05
Бусад биет бус хөрөнгө - Анхны өртөг	310,954,029.67	410,728,518.33
Бусад биет бус хөрөнгө - Хуримтлагдсан элэгдэл	-44,229,491.85	-27,493,565.28
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,298,886,548,947.83	408,964,892,088.34
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	22,286,262,772.89	20,478,508,059.49
Өглөг	5,201,564,657.82	2,962,811,817.29
Ажилчидтай холбогдсон тооцоо	211,188,281.84	239,607,083.23
Цалингийн өглөг	126,991,949.59	127,122,611.72
НДШ-ийн өглөг	34,340,848.38	36,836,679.45
ХАОАТ-ын өглөг	44,386,814.56	31,271,617.43
ҮЭ-ийн өглөг	4,418,669.31	44,376,174.63
Бараа үйлчилгээний зардлын тооцоо	1,303,864,185.94	808,215,825.23
Гэрэл цахилгааны тооцоо	3,008,829.00	903,192.00
Түлш халаалтын тооцоо	44,124,963.02	683,807.00

Шуудан холбооны тооцоо	1,000,156.86	524,795.00
Цэвэр, бохир усны тооцоо	898,000.00	26,000.00
Тээвэр шатахуунын тооцоо	4,690,970.00	1,620,000.00
Хоолын тооцоо	19,532,961.40	
Эмийн тооцоо	97,004.00	
Байрны түрээсийн тооцоо	24,624,130.00	1,199,931.18
Байрны засварын тооцоо	4,839,780.22	
Бусад зардлын тооцоо	1,201,047,391.44	803,258,100.05
Татаас, санхүүжилт, шилжүүлгийн тооцоо	3,043,292,812.64	140,221,245.36
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон тооцоо	26,533,194.00	26,533,194.00
Зээлийн хүүгийн тооцоо		14,220,000.00
Бусад өглөг	617,736,183.40	1,734,014,469.47
Байгууллагад төлөх өглөг	486,589,662.05	1,600,625,597.29
Хувь хүмүүст төлөх өглөг	131,146,521.35	133,388,872.18
Урьдчилж орсон орлого	17,179,648,428.31	17,515,696,242.20
Төсөвт байгууллага	16,743,822,732.96	17,370,692,236.33
Урьдчилж орсон орлого	16,743,822,732.96	17,370,607,356.33
Урьдчилж орсон хөрөнгийн орлого		84,880.00
Бусад урьдчилж орсон орлого	435,825,695.35	145,004,005.87
УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨР		131,026,007.48
Урт хугацаат зээл		131,026,007.48
Гадаад валют		131,026,007.48
Олон улсын санхүүгийн байгууллагаас		131,026,007.48
Санхүүгийн зээл		36,936,308.10
Төслийн зээл		94,089,699.38
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	22,381,213,086.13	20,609,534,066.97
Засгийн газрын хувь оролцоо	1,276,505,335,861.70	388,355,358,021.37
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ Орон нутгийн сан	810,757,539,119.36	145,834,138,789.08
Хуримтлагдсан үр дүн	-69,123,066,447.72	140,496,279,608.83
Өмнөх үеийн үр дүн	-69,123,066,447.72	116,744,865,894.98
Тайлант үеийн үр дүн		23,751,413,713.85
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	534,870,863,190.06	102,024,939,623.46
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,276,505,335,861.70	388,355,358,021.37
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,298,886,548,947.83	408,964,892,088.34

АУДИТ ХИЙГДСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,083,114,873,255.56	921,347,518,900.71
Гадаад орнуудаас үзүүлсэн	8,379,634,916.62	1,146,343,304.11
Урсгал		1,146,343,304.11
Олон улсын байгууллагын тусламж	283,309,367.03	
Урсгал тусламж		
Засгийн газрын бусад түвшнээс авах тусламж санхүүжилт	1,074,451,928,971.91	920,201,175,596.60
Улсын төвлөрсөн төсвөөс		919,611,104,994.60
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		866,469,541,483.24
Засгийн газрын нөөц хөрөнгө		
Хөрөнгийн		13,844,235,769.00
Санхүүгийн зээлээс санхүүжих		6,622,778,100.00
Тусламжийн сангаас санхүүжих	6,627,165,369.28	12,378,675,248.09
Нэмэлт санхүүжилтийн орлого		20,295,874,394.27
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж		49,068,155.11
Төсвийн жилийн явцад УИХаас соёрхон баталсан ЗГ хоорондын гэрээ болон ОУбайгууллага		633,145,705.54
ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс		666,598,275.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч		14,855,260,363.81
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		4,091,801,894.81
Бусад шатны (Орон нутгийн) төсвөөс авах санхүүгийн дэмжлэг		207,852,300.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		207,852,300.00
Засгийн газрын нөөц хөрөнгө		
Хөрөнгийн		
Төсөвт байгууллагаас		
Өр барагдуулах санхүүжилтийн орлого		
Хөрөнгийн		
ТЕЗ-аас олгосон санхүүжилт	185,607,686,038.00	
Нийгмийн даатгалын сангаас		382,218,302.00
НДС-ийн шилжүүлэг		382,218,302.00
Бусад Засгийн газрын тусгай зориулалтын сангаас санхүүжих		
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан		
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	86,640,175,013.35	147,017,052,089.45
Өмчийн орлого		2,229,743,190.39
Хүүгийн орлого		2,003,999,852.93
Түрээсийн орлого		225,743,337.46
Төрийн өмч түрээслүүлсний орлого		225,743,337.46
Бараа, үйлчилгээний борлуулалт		144,628,363,618.06
Төсөвт байгууллагуудын ажил, үйлчилгээний орлого		144,628,363,618.06
Үндсэн үйл ажиллагааны орлого		120,705,507,069.53

Үндсэн бус үйл ажиллагааны орлого		15,882,169,034.03
Урьд оны төсвийн хэмнэлтийн орлого		87,469,208.40
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		7,953,218,306.10
Торгууль, шимтгэл		550,000.00
Татварын бус бусад орлого		158,395,281.00
Хөрөнгийн орлого		158,395,281.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,169,755,048,268.91	1,068,364,570,990.16
АЖИЛЛАГСДЫН ЗАРДАЛ	507,955,908,331.22	120,192,680,588.83
Үндсэн болон нэмэгдэл цалин	458,027,130,324.21	108,537,480,530.47
Үндсэн цалин		103,786,875,795.47
Гэрээт ажилчдын цалин	16,366,269,371.94	4,379,666,334.08
Унаа хоолны хөнгөлөлт		73,768,837.00
Бусад нэмэгдлүүд		297,169,563.92
Үр дүнгийн урамшуулал		50,047,441.92
Илүү цагийн нэмэгдэл		110,632,050.00
Унаа, болон бусад нөхөн олговор		134,604,651.00
Бусад нэмэгдэл		1,885,421.00
Нийгмийн хамгааллын шимтгэл	49,928,778,007.01	11,655,200,058.36
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл		9,688,950,766.46
Тэтгэврийн даатгалын шимтгэл		7,601,702,172.90
Тэтгэмжийн даатгалын шимтгэл		748,027,022.61
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл		917,221,402.83
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл		196,468,866.07
Бүтцийн өөрчлөлтийн цалингийн НДШ		225,531,302.05
Эрүүл мэндийн даатгалын хураамж		1,966,249,291.90
УРСГАЛ ЗАРДАЛ	329,680,573,335.73	221,526,247,983.38
Бараа үйлчилгээний урсгал зардал	234,316,298,895.33	82,951,940,547.79
Тогтмол зардал		9,955,701,554.46
Гэрэл цахилгаан		3,157,714,897.98
Түлш, халаалт		5,179,549,987.51
Цэвэр, бохир ус		1,618,436,668.97
Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлттэй шууд холбоотой зардал		517,542,510.78
Хоол		416,523,731.82
Эм, вакцин		101,018,778.96
Бусад бараа үйлчилгээний зардал		72,478,696,482.55
Бичиг хэргийн зардал		1,127,178,119.79
Тээвэр, шатахуун		988,124,550.45
Шуудан, харилцаа холбоо		733,490,185.00
Дотоод албан томилолт		1,975,105,224.09
Гадаад албан томилолт		1,330,451,897.90
Ном, хэвлэл захиалах, худалдан авах		1,957,411,031.95
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага		7,991,455,397.62
Сургалт семинарын зардал		2,015,845,021.05
Эрдэм шинжилгээний ажил хийх		3,571,136,843.79
Жижиг эд хогшил худалдан авах		447,342,140.86
Жижиг эд хогшил худалдан авах \Багаж хэрэгсэл\		159,756,392.64
Жижиг эд хогшил худалдан авах \Тавилга\		121,390,840.00
Жижиг эд хогшил худалдан авах \Бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлс\		163,540,858.22

Жижиг эд хогшил худалдан авах \Програм хангамж\		2,654,050.00
Нормын болон дүрэмт хувцас, зөөлөн эдлэл		166,041,710.02
Төлбөр хураамж, жижиг татварууд		6,337,320,225.97
Харуул, хамгаалалтын зардал		448,886,080.00
Банкны үйлчилгээний хураамж		5,658,804.80
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр		17,287,753,258.09
ТӨГАҮ \Уран бүтээл хийлгэх, бэлтгүүлэх\		
ТӨГАҮ \Эрдэм, шинжилгээ, судалгааны ажлын хөлс\		8,547,443,836.73
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ		8,654,190,756.80
ТӨГАҮ \Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс \		24,094,710.74
ТӨГАҮ \Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох үйлчилгээний хөлс (гадаад) \		21,883,358.82
ТӨГАҮ \Эд хөрөнгийн даатгал\		2,369,295.00
ТӨГАҮ \Тээврийн хэрэгслийн даатгал\		8,960,300.00
ТӨГАҮ \Харуул, хамгаалалтын хөлс \		28,800,000.00
ТӨГАҮ \Тээврийн хэрэгслийн оношилгоо\		11,000.00
Маягт хэвлүүлэх зардал		380,300,060.29
Урсгал засвар		4,461,191,325.64
Биеийн тамирын уралдаан, тэмцээний зардал		335,215,522.04
Гадаадын зочны зардал		475,889,474.44
Бусад зардал		3,513,949,936.41
Засварын зардал		1,150,000.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		16,230,446,320.39
Аж ахуйн материал худалдан авах зардал		516,439,371.53
Бараа материал акталсны зардал		96,911,466.91
Газрын төлбөр		19,985,578.00
Ажил, үйлчилгээний хөлс		
Хог хаягдал устгах, цэвэрлэх зардал		3,491,000.00
Үдийн цай		60,525,935.52
Хөтөлбөр арга хэмжээний зардал	95,364,274,440.40	138,574,307,435.59
Төсвийн эрх захирагчдын арга хэмжээний зардал		122,225,597,353.88
Мал аж ахуйн үржлийн зардал		77,322,330.41
ЕБС-ийн сурах бичиг хэвлүүлэх, худалдан авах		5,471,722,714.27
Оюутны замын зардлын хөнгөлөлт- тэтгэлэг		105,365,326,432.00
Мэргэжил дээшлүүлэх зардал		80,652,411.00
Албан бус боловсрол		
Соёл урлаг хөгжүүлэх зардал		
Газрын хянан баталгаажуулах зардал		
Улсын нөөцийн бараа худалдан авах зардал		6,306,420.00
Хүнсний бүтээгдэхүүн бараа		4,761,420.00

Өвс тэжээлийн нөөц		1,545,000.00
Тусгай зориулалтын сан		
Халдвартын сан		
Мэдээлэл, сурталчилгааны ажил (гадаад, дотоод)		338,650,942.00
Урьд оны өр		45,652,729.48
Бусад төвлөрсөн арга хэмжээ		1,964,655,997.19
Урьд оны төсвийн хэмнэлтийн зарцуулалт		48,040,408.00
